

11

ГАДААДАД АЖИЛЛАГСАДЫН ГУЙВУУЛГА ХӨГЖИЛД ТУСТАЙ ЮУ?

А.Батсүх

Гадаадад ажиллагсадын гуйвуулга / ГАГ / нь бага орлогтой болон хөгжиж буй орнуудын тухайд улам бүр чухал үүрэг гүйцэтгэх боллоо. Зөвхөн дүн мэдээнд тусгагдсан хөрөнгийн урсгалын хэмжээ 2003 оны байдлаар дэлхийд 90.0-100.0 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь хөрөнгийн албан ёсны цэвэр урсгал/ 30.0тэрбум ам.долл. / -аас бараг 3 дахин их, гадаадын шууд хөрөнгө оруулалт/ 133.0 тэрбум ам.долл. / -ын дараа хоёрдугаарт орох санхүүжилтийн гадаад эх үүсвэр болоод байна. ГАГ-ын хэмжээ түүнийг хүлээн авагч 20 том орнуудад жилд 1.1-10.0 тэрбум ам.долларт хүрч ДНБ-ийх нь 7.0-37.3 хувийг бүрдүүлж байна. Манай орны жишээн дээр аваад үзэхэд л ГАГ нь юуны өмнө банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөний болон ханшийн бодлогод шууд нөлөөлөхүйц хэмжээнд хүрч үйлчилж байгаа билээ. Харин манай орны эдийн засгийн хөгжилд ГАГ нь чухам ямар нөлөөлөл үзүүлж байна вэ? гэдгийг илүү танин мэдэх сонирхол олон судлаачид, айл өрх болон иргэдэд буй гэдгийг дурьдая. Учир нь хариулт тийм ч энгийн бус юм. Юуны өмнө байдлыг товч тоймлон авч үзье.

ГАГ сүүлийн жилүүдэд түргэн хурдацтай өсч байна. Хавсралт №1-ийг үз. Энэ нь валютын ханш, урсгал болон хөрөнгийн тэнцлийг либералчилсан, дүн мэдээ гаргалт, банкаар дамжуулах технологи сайжирч өртөг буурсан, гадаадад ажиллагсадын тоо өсч байгаатай голчлон холбоотой юм. ГАГ-ын хэмжээ 2003 оны эцсийн байдлаар 128.3 сая ам.долларт хүрээд байна. Үүнийг 2003 оны ДНБ болон экспортын орлогын дүнд харьцуулбал ¹⁰ харгалзан 10.1 ба 20.5 хувьтай тэнцэнэ. Энэхүү харьцааг 1996-2000 оны жилийн дундажтай харьцуулбал харгалзан 5.0 ба 10.7 нэгжээр тус тус өссөн дүн гарна. ГАГ нь манай улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт / санхүүгийн ба

¹⁰ Энэхүү судалгаанд дурьдагдах санал, дүгнэлт нь зохиогчийнх бөгөөд Монголбанкны байр суурийг илтгэхгүй. Мэдээлэл цуглуулах, статистик боловсруулалт хийхэд туслалцаа үзүүлсэн Монголбанкны Валютын газрын ахлах эдийн засагч С.Сэлэнгэ, Мөнгөний бодлого, судалгааны газрын эдийн засагч Н.Ургамалсүвд нарт талархал илэрхийлье

богино хугацаат хөрөнгийн дүн ороогүй /-ыг 1997-2004 онуудын байдлаар жил бүр давж ирсэн дүнтэй байна. Хавсралт№ 5 –ийг үз.

ГАГ манай улсын төлбөрийн тэнцэлд чухал нөлөөлөл үзүүлж байдаг. Манай улсад хүлээн авч буй гуйвуулгын нийт дүн 2004 онд худалдааны тэнцэлийн алдагдалыг дангаараа хаах түвшинд анх удаа хүрэх тооцоотой байна. Хавсралт№1-ийг үз. Нөгөө талаас ГАГ-ын дүн мэдээ гаргалт сүүлийн жилүүдэд өмнөхөөс харьцангуй боловсронгуй болсноор төлбөрийн нийт тэнцэлийг хангахын тулд өмнө нь зөрүүгээр тооцдог байсан залруулгын хэмжээ эрс буурахад нөлөөлсөн.

Шууд бус сувгаар дамжин үйлчилж буй ГАГ-ын өөр нэг нөлөөлөл бол манай улсын гадаад валютын нөөцийн өсөлтөд нөлөөлөхүйц хүчин зүйл болж чадсан явдал юм. Тодруулбал Төв банкнаас валютын зах зээл дээр худалдан авсан ба худалдсан гадаад валютын цэвэр дүн 2001 оноос эхлэн багасах хандлагатай болсоныг дээрхитэй холбон авч үзэх үндэслэлтэй. Улмаар Монгол улсын гадаад өрийн төлбөрт валютын нөөцөөс зарцуулах боломжийг өргөтгөх үйлчилгээтэй явж ирснийг харгалзан үзүүштэй юм.

Нэгтгэн тоймловол: а/.ГАГ нь гадаад валютын тогтвортой эх үүсвэр болж чадсан, б/.манай улс дахь хөрөнгө оруулалт, банк санхүүгийн орчин сайжрахын хэрээр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Харин ГАГ-ын нөлөөлөлийг макро түвшинд гүнзгийрүүлэн сонирхох хэд хэдэн шалтгаан бий. Гол санаа нь дор дурьдсан асуултын хариултаас гарна.Тодруулбал онолын болон эмпирик судалгаануудын үр дүнгээс үзэхэд ГАГ нь макро эдийн засгийн голлох тэнцлүүдийг хангахад дээр дурьдсанчлан чухал байр суурь эзэлж байгаа хэдий ч эдийн засгийн хөгжилд ялангуяа урт хугацаанд чухам ямар нөлөөлөл үзүүлж байна вэ? гэдэг дээр хариулт тодорхой бус буйгаас үүдэлтэй. Бидэнд энэхүү судалгааг хийх явцад дотоод, гадаадын эрдэмтэдийн хийсэн дээрхи чиглэлийн 15 судалгааны үр дүнг харьцуулах боломж олдсон юм. Энэ чиглэлийн судалгаа эдийн засагчдын зүгээс өрхийн эдийн засгийн судалгааг эрчимтэй сонирхох болсон үеэс буюу 1970-аад оны эхнээс хийгдэж эхэлсэн байдаг. Орчин үед микро түвшний шинжилгээнд хэрэглэгдэж буй гол арга ч өрхийн төсвийн судалгаанд суурилж байна.

Онолын загваруудын дүнг дараахь байдлаар тоймлох боломжтой гэж үзэв. Үүнд: ГАГ-ын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөлийг тогтоохын тулд түүнийг гадаадад гарч ажил хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан нөхцөлтэй холбон авч үзэж байна. Энэ нь дурьдсан нөлөөлөлийг зөв танин мэдэх оновчтой арга мөн гэдэг дээр судлаачид ойролцоо санал, дүгнэлттэй байгаа нь ажиглагдлаа.

Бид энэхүү судалгаанд дээрхи аргыг авч ашиглахыг зорино. Судалгаанд шаардагдах орох үзүүлэлтүүдийн динамик, хамрах хүрээ хязгаарлагдмал, чанар хангалтгүй байсан зэрэг хүндрэлүүд учирч байсан хэдий ч загварын энгийн хувилбарыг ашиглан зарим дүгнэлт хийх боломжтой байв. Ийм хүндрэлүүд нийтлэг тохиолдож байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Загварын тавилыг ерөнхий байдлаар тоймловол:

ГАГ-ыг хүлээн авагч айл өрхийн төсөвт голлох байр суурь эзэлж байж магад хэмээн үзсэн зардлын үзүүлэлтүүдийг сонгон авсан. Хавсралт№ 5-ыг үз.

ГАГ нь нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нөлөөлж байдаг нь тодорхой тул макро зарим агрегат тоон үзүүлэлтүүдийг нэмж тусгав. Хавсралт№ 5-ийг үз.

Судалгааны үр дүнг товчоор илэрхийлбэл: ГАГ нь манай улсын эдийн засгийн өсөлтөнд өнөөг хүртэл эерэг нөлөөлөл үзүүлж байгаа хэдий ч мөн түүний болзошгүй сөрөг нөлөөлөлүүдийн талаар бодлогын түвшинд анхаарах цаг болсон гэж үзлээ. Энэ талаар дор илүү дэлгэрэнгүй авч үзье.

II. ГАГ БА ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАЛААР

Өмнө дурьдсанчлан гадаадаас гуйвуулгаар ирсэн мөнгө, хөрөнгийг юунд хэрхэн зарцуулж байна вэ? гэдгээс улбаалан эдийн засгийн өсөлтөд ГАГ-ын үзүүлэх нөлөөлөлийг тоймлоё. Шинжилгээнд ашигласан үзүүлэлтүүдийг Хавсралт № 5-д үзүүлэв. Үүнд:

-ГАГ-ын хэмжээ, 1990-2004 он жилээр,

-Бодит ДНБ-ий өсөлт, (Δy)

-Нэг хүнд ногдох ДНБ, (py)

-ДНБ-д ГАГ-ын эзлэх хувийн жин, (r)

-ДНБ-нд хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин, (i)

-Барилгын салбарын жилийн өсөлт, (Δc)

-Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарын жилийн өсөлт, ($\Delta reals$)

-Дотоодын их, дээд сургууль төгсөгчдийн өөрчлөлт, ($\Delta grad$)

-Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, (Δdep)

Өгөгдлүүдийг ашиглан ГАГ болон бодит ДНБ-ий өсөлтийн хоорондын хамааралыг дараахь тэгшитгэлээр илэрхийлье.

$$\Delta y = \alpha_1 + \alpha_2 py + \alpha_3 r + \alpha_4 i + e \quad (1)$$

Энд (1)-ийг дараахь байдлаар өөрчлөн илэрхийлэх боломжтойг анзаарья.

$$\Delta y = \alpha_1 + \alpha_2 py + \alpha_3 \Delta r + \alpha_4 i + e \quad (2)$$

Энэ нь Δy ба Δr -ийн хоорондын хамааралыг илүү тодорхой илэрхийлэх гэсэнтэй холбоотой юм.

Манайд ДНБ-д цэвэр хувийн хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин, ДНБ-ийг улирлаар тооцдоггүйгээс (1)-ийн үр дүнг хэр зэрэг найдвартай болохыг шалгах боломж хязгаарлагдмал байсныг тэмдэглэе.

ГАГ ба түүний зарцуулалтын бүтцийг дараахь тэгшитгэлүүдээр илэрхийлье.

$$\Delta r = \beta_1 + \beta_2 \Delta c + \beta_3 \Delta reals + \beta_4 \Delta grad + e \quad (3)$$

$$\Delta r = \beta_1 + \beta_2 \Delta c + \beta_3 \Delta reals + \beta_4 \Delta grad + \beta_5 \Delta dep + e \quad (4)$$

(3) ба (4)-ийн гол санаа нь гадаадад ажиллагсадаас ирүүлж буй гуйвуулгыг нутагтаа үлдсэн айл өрх, иргэд өөрөөр хэлбэл хүлээн авагч талын зүгээс боловсрол эзэмших, байр орон сууц барих болон эрүүл мэндээ хамгаалахад зарцуулах г.м эдийн засгийн хөгжилд урт хугацаанд илүү тустай хэлбэрээр өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтад ашиглах сонирхол давамгайлж буй нь техникийн хувьд дэмжигдвэл өдөр тутмын буюу ахуйн /хоол хүнс, хувцас

худалдан авах г.м/ хэрэглээнд бага зарцуулагдаж байна гэж үзэх боломжтойд оршино.

III. ЭМПИРИК ҮР ДҮНГИЙН ТАЛААР

1990-2004 оны өгөгдлүүдийг ашиглан (1)-ээс (4)-ийн үнэлгээг эконометрикийн Eviews 5.0 програмыг ашиглан гүйцэтгэсэн дүнг Хавсралт № 2; 3; 4- д тус тус үзүүлэв. Энд тэмдэглэн хэлэх нэг зүйл бол 1996-2004 оны улирлын өгөгдлүүдийг ашиглан тэгшитгэл (1)-ээс (4)-ийн үнэлгээг хийх боломж техникийн хувьд байсан хэдий ч өөр төрлийн хүндрэлүүд гарах эрсдэлтэйг бодолцон энэ удаад хойш тавьсан. Тухайлбал тэгшитгэл (1)-д ДНБ-д харьцуулсан харьцаануудыг абсолютаар авч ашиглахад хүрэх учраас серийн болон heteroskedasticity хүндрэлүүд нэмэгдэх талтай байв.

Үнэлгээний үр дүнгээс үзэхэд тэгшитгэл (1)-ийн хувьд буюу ДНБ-ий өсөлт ба ГАГ-ын хооронд эерэг хамааралтай, итгэлцүүрүүдийн утга 10 %-ийн ач холбогдолын түвшинд хүлээж авах боломжтой, тэгшитгэлийн үлдэгдэл серийн корреляцигүй байна. Тодруулбал гадаадад ажиллагсадаас хүлээн авч буй гуйвуулга 2.6 хувиар өсөхөд манай улсын ДНБ нэг хувиар нэмэгдэж байна. Ийм хандлагыг өмнө дурьдсанчлан манай улс дахь хөрөнгө оруулалт, санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх ерөнхий орчин нөхцөл сайжирсантай холбон авч үзэх үндэслэлтэй. Үүнийг гадаад худалдааны өртөг хямд, нээлттэй, M2 / ДНБ-ний харьцааны түргэн нэмэгдэж байгаа зэргээр илэрхийлж болно.

Харин тэгшитгэл (2)-ийн үнэлгээний үр дүн дээрхи дүгнэлтийг болгоомжтой хэрэглэхийг анхааруулах мэт байна. Учир нь ГАГ-ын өөрчлөлт нь ДНБ-ий өсөлтийг тайлбарлах боломжгүй байгаад оршино.

ГАГ-ын зарцуулалтын бүтэцтэй холбоотой гэж үзсэн хүчин зүйлсийг тодорхойлох тэгшитгэл (3) ба (4)-ийн хувьд бидний авч үзсэн өгөгдлүүдийн хүрээнд үлдэгдэл бүгд серийн корреляцийн хамааралтай байгааг үнэлгээний дүн харууллаа. Энд макро түвшний судалгаанд илүү анхаарал татах үр дүн бол тэгшитгэл (1) ба (2)-ийн үнэлгээг зэрэг авч үзэх явдал байв. Учир нь нэгдүгээрт: 1990-2004 оны үзүүлэлтүүд нь зах зээлд шилжих шилжилтийн бодлого / тогтворжуулах, бүтцийн өөрчлөлт, либералчлал, хувийн хэвшил болон зах зээлийг бүрдүүлэх / -ыг хэрэгжүүлж байсан үе тул ДНБ-ий динамикт дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл богино хугацаанд хүчтэй нөлөөлж байсныг бодолцох шаардлагатай байв. Хоёрдугаарт: техникийн хувьд тэгшитгэл(1)-ийн үнэлгээний үр дүнг илүү бататгах боломжтой байсан. Иймд бид судалгаандаа 1990-2004 оны тоон мэдээлэлийг ашиглан ДНБ ба ГАГ-ын хоорондын хамааралыг илэрхийлсэн тэгшитгэл(1)-ийг дахин үнэлсэн. Хавсралт №4-ийг үз. Ингэхдээ дор дурьдсан өөрчлөлтийг оруулав. Үүнд:

- ДНБ-д сөрөг нөлөөлөл үзүүлж байсан хүчин зүйлсийг дамми хувьсагч D1-ээр, эерэг нөлөөлөлийг D2-оор арилгасан. Тодруулбал D1-ээр 1991-1992 болон 2000-2001 онуудыг хамруулав. Энэ нь манай улсын эдийн засагт эрчимтэй уналт үргэлжилсэн болон ган зуд, малын халдварт өвчин нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хүчтэй нөлөөлсөн үе юм. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт өндөр байсан зэрэг бусад эерэг нөлөөлөлүүдийг D2-оор тэмдэглэсэн.

- Тэгшитгэл(1)-ийн тайлбарлагч хүчин зүйлст байсан (ру) буюу нэг хүнд ногдох ДНБ-ийг санхүүгийн зуучлалыг илтгэх банкны системийн бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтээр орлуулсан.

Өөрчлөлтүүдийг тусгаснаар тэгшитгэл(1)-ийн үнэлгээ сайжирсан бөгөөд үүнийг Хавсралт№ 2 ба 4 -ийг хооронд нь харьцуулснаар харж болно. Шинэчилсэн үнэлгээний дүнг товчлон илэрхийлбэл:

- Итгэлцүүрүүдийн утга 10 % ач холбогдлын түвшинд статистик үнэлгээнийхээ хувьд хүлээж авах боломжтой хэвээр, тэгшитгэлийн үлдэгдэл серийн корреляцигүй байна.

- ДНБ-ий өсөлтөд банкны системийн бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө хамгийн их эерэг, хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин сулавтар эерэг нөлөөлөлтэй.

- Гадаадад ажиллагсадын гуйвуулга ДНБ-ий өсөлтөд бидний хүлээж байсанчлан эерэг бус харин сөрөг нөлөөлөл үзүүлдэг гэсэн дүгнэлт гарлаа.

Энэхүү сөрөг хамаарал нь илүүтэйгээр техникийн шинжтэй өөрөөр хэлбэл харьцангуй богино хугацааны тоон мэдээлэлийг авч ашигласантай холбоотой байж болох талтай.

Тухайлбал ГАГ/ДНБ гэсэн харьцаа байнга өсч өөрөөр хэлбэл ГАГ-ын өсөлт ДНБ-ийхээс түрүүлж ирсэн байхад байгаль цаг агаарын г.м таагүй нөлөөлөлөөс шалтгаалан ДНБ-ий өсөлт 2000-2001 онуудад буурч улмаар инерц нь дараахь онуудад хадгалагдаж ирсэн байх жишээтэй.Өөрөөр хэлбэл ДНБ-д үзүүлэх шилжилтийн үеийн бодлогын нөлөөлөл нь ГАГ-ынхаас давамгайлах шинжтэй байсантай холбоотой гэж үзнэ. Хангалттай урт хугацааны макро тоон мэдээлэлийг ашиглах тохиолдолд дээр дурьдсан богино хугацааны буюу тохиолдлын хамааралыг бус ерөнхий хамааралыг илрүүлэх боломжтой хэдий ч энэ нь манай орны хувьд практикт хэрэгжих магадлал нэн бага юм. Тэгшитгэл (1) - (4)-ийн үнэлгээнээс үзэхэд манай орны хувьд ГАГ-ын нөлөөлөлийг макро түвшний агрегат үзүүлэлтүүдийг ашиглан илэрхийлэх боломж ихээхэн хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна.

Иймд ГАГ хэрхэн зарцуулагдаж байгаа талаархи өрхийн судалгааны мэдээлэлийн баазыг бүрдүүлж ашиглах нь илгээгч болон хүлээн авагч талуудын араншинг тодорхойлох бараг цорын ганц гарц болох юм.

IV. ДҮГНЭЛТ

Энд сонгон авсан өгөгдлүүдийг ашиглан хийсэн судалгааны үр дүнг дараахь байдлаар хураангуйлан илэрхийлэж болно. Үүнд:

- Манай улсын хувьд ГАГ нь өнөөг хүртэл бодит ДНБ-ий өсөлтийг дэмжих үйлчлэлтэй явж иржээ.

- Нөгөө талаас ГАГ-ын өөрчлөлт ДНБ-ий өсөлтийг тайлбарлах боломжгүй байгаа нь хүн амын орлого бага улс орны хувьд эдийн засгийн өсөлтөд ГАГ сөрөгөөр нөлөөлөх магадлал өндөр байдаг талаархи онолын дүгнэлтүүдийн сулавтар баталгаа болж үйлчлэх боломжтой байна. Аль ч тохиолдолд ГАГ-ын сөрөг шинж бүхий нөлөөлөлүүдийг бодлогын түвшинд анхаарч эхлэх цаг болсон гэж үзнэ. Үүнийг манай улсын банкны систем дэх иргэдийн хадгаламжийн хэмжээ, бүтэц зэргээс ч давхар харж болох талтай. Ийнхүү тааламжгүй нөлөөлөл үзүүлэх гол шалтгааныг ГАГ-ыг хүлээн авагч тал түүнийг, хэрэглээнд голчлон зарцуулж байдаг / буцаан төлдөггүй / -тай холбон үздэг. Өөрөөр хэлбэл хүлээн авагч талын зүгээс ажил хөдөлмөр эрхлэх, хөрөнгийн хуримтлалаа ахиу нэмэгдүүлэх сонирхол нь буурч байж болно гэсэн санаа юм.

- ГАГ-ын нөлөөлөлийг загварчлалын аргаар тооцохдоо өгөгдлүүдийн динамик, чанар хангалтгүй нөхцөлд өрхийн судалгааны мэдээлэлийн баазыг бүрдүүлж ашиглах нь илүү үр дүнтэй байх болно. Энэ нь "ялгавар доторхи ялгаврын" аргыг шинжилгээнд ашиглах бололцоо олгох давуу талтай. Учир нь бидний гарган авсан дүгнэлт нь ажиглалт, судалгааны энгийн аргад үндэслэгдсэнийг дурьдая. Илүү чанартай тоон мэдээлэлийг ашиглаж, статистик аргуудаар шалгах хэрэгтэй нь макро нөлөөлөлийг тооцсон дүнгээс харагдлаа.

- ГАГ-ын талаархи микро түвшний судалгаа буюу мөнгөн гуйвуулгын өртөг, зарцуулалтын бүтэц, гарал үүслийн байршил, төгрөгийн ханш болон ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлж байна вэ ? г.м асуултууд нээлттэй хэвээр үлдэж байна.

Хавсралт№1

Гадаадад ажиллагсадын гуйвуулга / ГАГ /-ын хэмжээ

Он	ГАГ-ын нийт дүн, сая.ам.дол	ДНБ оны үнээр, сая.₮	Экспорт сая.ам.долл	ГАГ/ДНБ, %	ГАГ/экспорт, %	Худалдааны тэнцэл, +/-
1	2	3	4	5	6	7
1990	0.01	10465.0	660.7	0.0	0.0	-578.8
1991	0.03	18909.6	348.0	0.0	0.0	-140.0
1992	0.3	47298.0	388.4	0.0	0.1	-62.6
1993	1.2	194835.9	382.6	0.2	0.3	-8.7
1994	2.94	324400.7	356.1	0.4	0.8	-3.4
1995	5.16	550253.7	473.3	0.4	1.1	-22.0
1996	6.45	646559.3	424.3	0.5	1.5	-87.4
1997	41.3	832635.6	568.5	3.9	7.3	65.1
1998	43.0	817393.4	462.3	4.4	9.3	-120.1
1999	66.8	925345.8	454.2	7.4	14.7	-112.9
2000	83.0	1018886.0	535.8	8.8	15.5	-140.1
2001	93.8	1115641.0	459.9	9.2	20.4	-150.4
2002	111.8	1240787.0	523.9	10.0	21.3	-228.9
2003	128.3	1461169.0	627.3	10.1	20.5	-200.0
2004 ХБГ	279.5	1720695.0	738.6	19.3	37.8	-212.4

Эх үүсвэр: ДНБ-ий мэдээлэл УСГ, бусад мэдээлэл нь Монголбанк

ДНБ-ий өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээ

Тэгшитгэл (1)

Dependent Variable: DLOG(Y)
 Method: Least Squares
 Sample (adjusted): 1992 2004
 Included Observations: 13 after adjustments
 Convergence achieved after 11 iterations

Variable	Coefficient	Std.Error	t-Statistic	Prob.
C	0.612094	0.213416	2.868084	0.0209
LOG(PY)	-0.007063	0.002974	-2.374957	0.0449
LOG(R)	0.026520	0.005904	4.491897	0.0020
LOG(I)	-0.186242	0.067013	-2.779194	0.0240
AR(2)	-0.467541	0.119442	-3.914380	0.0045
R-squared	0.785853	Mean dependent var		0.019297
Adjusted R-squared	0.678780	S.D.dependent var		0.043027
S.E.of regression	0.024386	Akaike info criterion		-4.305904
Sum squared resid.	0.004757	Schwarz criterion		-4.088616
Log likelihood	32.98838	F-statistic		7.339388
Durbin-Watson stat	1.302671	Prob(F-statistic)		0.008714
Breusch-Godfrey Serial Correlation LM Test:				
F-statistic	0.487400	Probability		0.636588
Obs*R-squared	1.816883	Probability		0.403152

Тэгшитгэл(2)

Dependent Variable:DLOG(Y)
 Method:Least Squares
 Sample(adjusted):1993 2004
 Included observations:12 after adjustments
 Convergence achieved after 7 iterations

Variable	Coefficient	Std.Error	t-Statistic	Prob.
C	0.430294	0.145016	2.967218	0.0209
LOG(PY)	0.004607	0.003076	1.497654	0.1779
DLOG(R)	-0.009350	0.007521	-1.243115	0.2538
LOG(I)	-0.130169	0.045677	-2.849791	0.0247
AR(2)	0.390998	0.068977	5.668565	0.0008
R-squared	0.705442	Mean dependent var		0.029222
Adjusted R-squared	0.537123	S.D.dependent var		0.024955
S.E.of regression	0.016978	Akaike info criterion		-5.019410
Sum squared resid.	0.002018	Schwarz criterion		-4.817365
Log likelihood	35.11646	F-statistic		4.191105
Durbin-Watson stat	1.430208	Prob(F-statistic)		0.048118
Inverted AR Roots	0.63	0.63		
Breusch-Godfrey Serial Correlation LM Test:				
F-statistic	0.421553	Probability		0.669793
Obs*R-squared	1.334765	Probability		0.513050

ДНБ-ий өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээ

Тэгшитгэл (1)-ийн шинэчилсэн үнэлгээ

Dependent Variable: DLOG(Y)

Method: Least Squares

Sample (adjusted):1991 2004

Included Observations:14 after adjustments

Variable	Coefficient	Std.Error	t-Statistic	Prob.
C	-0.445321	0.047908	-9.295349	0.0000
I(-1)	0.002679	0.000707	3.788330	0.0053
R(-1)	-0.007328	0.001589	-4.611897	0.0017
LOG(DEP)	0.038729	0.004445	8.712425	0.0000
D1	-0.019831	0.008787	-2.256920	0.0540
D2	0.042808	0.009524	4.494538	0.0020
R-squared	0.983407	Mean dependent var		0.010989
Adjusted R-squared	0.973036	S.D.dependent var		0.051724
S.E.of regression	0.008493	Akaike info criterion		-6.401517
Sum squared resid.	0.000577	Schwarz criterion		-6.127635
Log likelihood	50.81062	F-statistic		94.82587
Durbin-Watson stat	2.360788	Prob(F-statistic)		0.000001
Breusch-Godfrey Serial Correlation LM Test:				
F-statistic	0.509967	Probability		0.624388
Obs*R-squared	2.034076	Probability		0.361665

ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

ГАГ-ЫН НӨЛӨӨЛӨЛИЙН ҮНЭЛТЭНД АШИГЛАСАН ОРОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хавсралт № 5

	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	
ГАГ, сая.ам.долл.*	0.01	0.03	0.3	1.2*	2.94	5.16	6.45	41.3	43	66.8	83	93.8	111.74	128.3	279.5		
ГАГ, сая.₮*	0.052	0.654	12.0	329.52	1203.342	2306.004	3529.44	32688.3	36008.2	68309.68	89449.1	102964.26	124199.01	147094.67	329217.46		
ДНБ оны үнээр, сая.₮	10730.9	10465	18909.6	47298	194835.9	324400.7	550253.7	646559.3	832635.6	817393.4	925345.8	1018885.7	1115641.4	1240786.8	1461169.1	1720694.6	
ГАГ/ДНБ, %	0.00	0.00	0.00	0.03	0.17	0.37	0.42	0.55	3.92	4.41	7.38	8.78	9.23	10.01	10.07	19.13	
Нэг хүнд ногдох ДНБ, 1995 оны үнээр, мян.₮	322.701	306.711	271.693	2413959	231.9939	2351011	246.2371	248.4472	255.007	260.495	265.5763	264.598	263.5088	270.3816	281.8073	293.71582	
ДНБ, 1995 оны үнээр, мян.₮	651469	635075.2	576351.1	521611	505946.4	517583.7	550253.7	563201	585719.8	606409.8	625910.2	632521.5	639013	664868.3	701756.6	740691.54	
ХО/ДНБ, %	35.4	24.5	14.7	8.6	18.7	15.2	15.5	20.3	20	23.7	25.7	25.6	24.9	24.8	23.4	22.079032	
Барилгын салбарын нэмэгдэл өртөг, 1995 оны үнээр, сая.₮	26290.8	19821.6	16555.2	9019.5	7559.3	8353.6	9237	9479.2	9223.6	9124.6	9267.8	7915.9	8772.8	10399.2	11713.1	13193.006	
Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажилл-ны нэмэгдэл өртөг, 1995 оны үнээр, сая.₮																	
Дотоодын их, дээд сургуулийг төгсөгчдийн тоо								3465.7	3610.1	3525.1	3822.9	3642.4	4097.6	4390.2	5495.3	5599.7	5706.0834
Банкны системийн бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, сая.₮*	1577.9	883.2	2601.1	5412.1	24215.8	43905.8	59408.1	64093.7	93956.6	84667.6	105341.3	128067.7	174908.9	282397.8	490499	693954.5	
Гадаадын шууд ХО, сая.ам.долл.	0.00	0.00	0.00	0.17	1.09	0.87	0.80	1.35	2.37	1.94	3.36	5.68	6.20	6.97	10.32	15.21	
Жилийн дундаж спот ханш, ₮*		5.2	21.8	40	274.6	409.3	446.9	547.2	791	837.4	1022.6	1077.7	1097.7	1111.5	1146.49	1177.88	
Банкны системийн бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө/ДНБ, %	14.70	8.44	13.76	11.44	12.43	13.53	10.80	9.91	11.28	10.36	11.38	12.57	15.68	22.76	33.57	40.33	

Эх үүсвэр: * Монголбанкны мэдээлэл

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

А.Батсүх., "Даяаршил ба мөнгө, санхүүгийн бодлого: концепцийн асуудлуудын талаар" „Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгийн газар, Монгол Улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Даяаршил ба Монгол улс: Үндэсний болон хүний аюулгүй байдал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл., 2004 . хх.126-137 Улаанбаатар хот

А.Батсүх. "Банкны салбар дахь хөдөлмөрийн нийлүүлэлтийг шинжлэх арга зүйн талаар товчхон", "ЭДИЙН ЗАСАГ: онол, практик" сэтгүүл., 2003 №214(10)хх.39-43

С.Сэлэнгэ., "Remittance income by Mongolian Workers", Paper presented at the International Conference on " Small saving Mobilization in Asia and Remittance", Tokyo, Japan. 2004

Asian Development Outlook 2004., "Special Chapter: Foreign Direct Investment in Developing Asia: Mongolia" „ADB 2004., pp.60-63

Chris Becker., "International Capital Movements from an Australian Perspective" Occasional Papers №37., The SEASEN Centre., 2003

Dilip Ratha., "Workers' Remittances: An Important and Stable Source of External Development Finance" „Global Development Finance 2003 - Striving for Stability in Development Finance., Chapter VII, World Bank., pp.157-175

"Enhancing the Development Effect of Workers' Remittances to Developing Countries", Appendix A., Global Development Finance 2004., World Bank., pp.169-173

Jacques Bongha-Hadbe., "No evidence of slowdown in Moroccan workers' remittances", IMF SURVEY, IMF. Volume 33, Number 14, July 26, 2004. pp.222-223

Kevin Mellyn., "Worker Remittances as a Development Tool : Opportunity for the Philippines", ADB., Manila, Philippines., June.2003. pp.16-17.

Manuel Orozco., "Worker Remittances in an International Scope", Washington, DC: INTER-AMERICAN DIALOGUE RESEARCH SERIES., Working Paper, March 2003.

Ralph Chami, Connel Fullenkamp, and Samir Jahjah., "Are Immigrant Remittance Flows a Source of Capital for Development? " „, Volume 51: Special Issue of IMF Staff Papers, June 2004. Papers presented at the IMF's Fourth Annual Research Conference, November 6-7, 2003

"Remittances: Development Impact and Future Prospects", Edited by Samuel Munzele Maimbo, Dilip 2004, Summary

Sangdai Ryou., "Bank restructuring in selected emerging economies: rationale, consequences and strategies", The South East Asian Central Banks Research and Training center (The SEASEN Centre), Kuala Lumpur, Malaysia., Staff Papers №70, 2004 pp.5-15

Sushil Ram Mathema., "Managing and Monitoring Direct and Portfolio Investment Flows: A Comparative Study of the SEASEN Countries", The SEACEN Centre, Kuala Lumpur, Malaysia., 2004., pp.41-49

Hiroshi Ueno. "Assessing Transition Policies: the Case of Mongolia", Journal of International Cooperation Studies, Volume 8, Number 1, June 2000., pp.154-155

Монголбанк Жилийн Тайлан 2003